

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны
ямны 2025 оны 12 дугаар сарын 12-ны
өдрийн 03/5/3 дугаар албан бичгийн хавсралт



ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ АЛБАН ХААГЧДЫН
АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2024.02.27

д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилт от түвшин	Хэрэгжү үлэх хугацаа	Хариуцах нэгж, албан тушаалтан	Хэрэгжилтийн тайлан	Хэрэг жилт ийн хувь
Нэг.Стратеги төлөвлөгөө 5.1.1 Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах зорилтын хүрээнд хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх								
1.1	Засгийн газар, төрийн бусад байгууллагас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	110	128	1-4 дүгээр улиралд	Төрийн захиргааны удирдлагын газар	Тус яамнаас 2024 оны жилийн эцсийн байдлаар албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх зорилгоор засгийн газар болон бусад байгууллагаас зохион байгуулсан 11 удаагийн сургалтад давхардсан тоогоор 455 албан хаагчийг хамруулсан. Үүнд: 1.Удирдлагын академиас зохион байгуулсан Менторшип хөтөлбөрт 3 албан хаагч, 2. Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад 19 албан хаагч, 3.Critical thinking буюу эргэцүүлэх сэтгэлгээний арга барил, асуудалд бодитой хандах, нөхцөл байдлыг зөв үнэлж дүгнэн шийдвэр гаргах чадварыг сургалтыг нийт 45 албан хаагч, 4.Албан хаагчдын нийгмийн баталгааны хөтөлбөр, хөдөлмөрийн дотоод журамтай холбоотой судалгаа, өөрчлөлтийн талаарх танилцуулах сургалт 20 албан хаагч. 5.“Нийгмийн сүлжээн дэх эрх зүйн зохицуулалт”, “Хэвлэлийн өөрийн зохицуулалтын туршлага” /Герман	100%

						Улс болон бусад орны сайн туршлагаас/ сургалтад 40 албан хаагч, 6.JICE JDS Монгол дахь төлөөлөгчийн газраас “Хүний нөөцийг хөгжүүлэх JDS тэтгэлэгт хөтөлбөр”-ийн танилцуулах сургалтыг цахимаар нийт 25 албан хаагч оролцож мэдээлэл авсан, 7.“Төрийн албан хаагчийн ёс зүй ба эрүүл мэнд” сургалтад 38 албан хаагч, 8.Жендерийн Үндэсний хорооноос зохион байгуулсан “Жендерийн харьцаа” сэдэвт сургалтад 68 албан хаагч, 9.Төрийн албаны зөвлөлөөс долоо хоног болгоны зохион байгуулдаг пүрэв гариг бүр зохион байгуулгагддаг “7:4:10” сэдэвт сургалтад нэг удаагийн 71 албан хаагч, 10.Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулах, олон нийтийн авлигын талаарх мэдлэгийг дээшлүүлэх” цахим сургалтад 53 албан хаагч, 11.Онцгой байдлын ерөнхий газраас зохион байгуулсан Гамшгийн үед ямар арга хэмжээ авах талаар сургалтад 73 албан хаагч тус тус оролцсон байна.	
1.2	Байгууллагын удирдах албан тушаалтнуудыг Удирдлагын академи болон Олон Улсын төсөл хөтөлбөрүүдээс хэрэгжүүлж байгаа	Сургалтад хамрагдсан Удирдах албан тушаалтны тоо	7	12	Жилдээ	ТЗУГ-ын Хүний нөөц, дотоод сургалт хариуцсан Ахлах шинжээч Яамны газар хэлтсийн дарга 8 удирдах албан тушаалтныг Удирдлагын академийн ахлах болон эрхэлсэн түшмэлийн багц сургалтад, Удирдлагын академийн ментор бэлтгэх сургалтад 3 Ахлах шинжээч, Олон Улсын төсөл хөтөлбөрүүдийн удирдах албан тушаалтны сургалтад нийт 7 албан хаагч, нийт 18 удирдах албан тушаалтныг тус тус хамруулаад байна. Үүнд: 1.Удирдлагын академийн ахлах болон эрхэлсэн түшмэлийн сургалт-8,	100%

	манлайллын сургалтууд үе шаттай хамруулах.						2.Удирдлагын академийн ментор бэлтгэх 2024 оны “Удирдахуйн онол практикийн асуудлууд” сэдэвт сургалтад 3 Ахлах шинжээч 3.Олон улсын төсөл хөтөлбөрүүдээс манлайлал болон удирдахуйн онол, практикийн чиглэлээр зохион байгуулсан сургалтад 7 удирдах албан тушаалтан тус тус оролцсон. (Япон, БНСУ, БНКУ, БНХАУ, БНФУ)	
Хоёр. Стратеги төлөвлөгөөний 5.1.3.Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар байгууллагын албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааны бодлого боловсруулан төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилт								
2.1	Байгууллагын албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах.	Батлагдсан төлөвлөгөөний тоо	-	1	1-р улиралд	ТЗУГ-ын Хүний нөөц, дотоод сургалт хариуцсан Ахлах шинжээч	-Байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг шинэчлэн батлуулахаар ТНБД-ын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн Б/54 дүгээр тушаалаар Удирдлагын академийн судлаач дэд профессор 2 багштай 8.000.000 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 1 хөтөлбөр, 3 журмын төсөл боловсруулж батлуулсан.Үүнд: 1. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, 2. Албан томилолтоор ажиллах журам, 3. Ажилтныг зайнаас цахимаар ажиллуулах журам, Мөн 2024-2026 онд хэрэгжүүлэх “Сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг шинээр боловсруулсан. -Албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөг шинэчлэн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын өгсөн зөвлөмж, чиглэлийн дагуу шинэчлэн боловсруулан, батлуулж, зөвлөмжийн дагуу хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан.	100%
2.2	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан	Тайлан мэдээг тухай бүр гаргах	-	-	Жилдээ	ТЗУГ-ын Хүний нөөц, дотоод сургалт хариуцсан	Төрийн албаны мерит зарчмыг хангах үүднээс 2024 онд 5 албан хаагчийг албан тушаалд шатлан дэвшүүлж, ангилал зэрэглэлийг ахиулах, 4 албан хаагчийг ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн удирдах албан хаагчдыг нэгж хооронд шилжүүлэн томилох, өөр байгууллагаас 2 албан хаагч сэлгэн ажиллуулахтай холбоотой шийдвэрүүд гарсан, өөр	100%

	хаагчдын шилжилт хөдөлгөөний тайлан мэдээг тухай бүр гаргаж, удирдлагуудад танилцуулж, мэдээллээр хангах.					Ахлах шинжээч	байгууллага руу 3 албан хаагч шилжин томилогдсон, 3 албан хаагч ажил хавсран гүйцэтгүүлэх шийдвэр гарсан. 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 17 албан хаагчийн шилжилт хөдөлгөөн хийгдсэн байна. Мөн албан хаагчдыг хөгжих, суралцахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт оролцох тодорхойлолт санал гаргах, суралцах хугацаанд ажлын цагаас чөлөөлж цалин хөлсийг олгосон. -Байгууллагын бүтэц орон тоо, албан тушаалын нэр, ангилал, зэрэглэл өөрчлөгдсөнтэй холбоотойгоор чиг үүргийн шинжилгээг үндэслэн албан хаагчдын албан тушаалын ангилал зэрэглэлийг нэмэгдүүлсэн. /ТНБД-ын 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/ 80 дугаар тушаал/	
2.3	Орон сууцны нөхцөлөө сайжруулах, гэр болон төвлөрсөн халаалтгүй галлагаатай байшинд амьдардаг ажилтанд түлээ, түлш авахад нь зориулж мөнгөн тусламж олгох.	Мөнгөн тусламж олгосон албан хаагчдын тоо	6	7	1-4 дүгээр улиралд	Төрийн захиргааны удирдлагын газар	Тус яамнаас гэр болон төвлөрсөн халаалтгүй галлагаатай байшинд амьдардаг ажилтанд түлээ, түлш авахад нь зориулж 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 5 албан хаагч хүсэлт гаргасан бөгөөд “Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам”-д заасны дагуу 5 албан хаагчид тус бүр 300,000 төгрөг, нийт 1,500,000 төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон. /ТНБД-ын 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн Б/76 дугаар тушаал/	100%
2.4	Цалин хөлс, шагнал урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх.	Зэрэг дэвийн нэмэгдэл, шагнал урамшуула	74	Нийт ажиллаж байгаа албан	Жилд 2 удаа	Төрийн захиргааны	“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газрын 2020-2024 оны хөтөлбөрт заасан зорилтыг биелүүлэх хүрээнд “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийг хэрэгжүүлэхэд орон нутагт дэмжлэг үзүүлэх ажилд 6	100%

		лд хамруулсан албан хаагчдын тоо		хаагчдийн тоогоор		удирдлагын газар	албан хаагч, МУ-ын Ерөнхий сайдын 2023 оны 206 дугаар захирамжаар байгуулагдсан эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд үр дүнтэй, идэвх санаачилгатай ажилласан 7 албан хаагчийг албан тушаалын сарын үндсэн цалингаар урамшуулсан, нийт 13 албан хаагчид Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн Б/71 дүгээр тушаалаар 26,760,000 төгрөгийн урамшуулал олгосон. Мөн эхний хагас жилийн гүйцэтгэлийн үнэлгээ, үр дүнг үнэлсэн урамшуулалд 65 албан хаагчдад Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн А/154 дүгээр тушаалаар 120,869,500.00 төгрөгийн урамшуулал, жилийн эцсийн гүйцэтгэлийн үнэлгээ, үр дүнгийн урамшуулалд 60 албан хаагчдад Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/179 дүгээр тушаалаар 104,089,000.00 төгрөгийн урамшууллыг тус тус олгосон.	
2.5	Шинээр гэр бүл болсон, хүүхэдтэй болсон, ар гэрт нь гачигдал гарсан албан хаагчдад санхүүгийн тусламж, дэмжлэг үзүүлэх.	Тусламж, дэмжлэг олгосон албан хаагчдын тоо	7	-	Жилдээ	Төрийн захиргааны удирдлагын газар	Тус яамнаас 2024 оны жилийн эцсийн байдлаар Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу шинээр гэр бүл болсон, шинэ хүүхэдтэй болсон, ар гэрт нь гачигдал гарсан албан хаагчдад санхүүгийн тусламж, дэмжлэгийг нийт 15 албан хаагчдад 4.800.000 төгрөгийн мөнгөн тусламжийг үзүүлсэн байна. Үүнд: 1. Шинээр гэр бүл болсон 2 албан хаагчид 1 сая төгрөг, 2. Ар гэрийн гачигдал гарсан 6 албан хаагчид 1.700.000 төгрөг, 3. Шинээр хүүхэдтэй болсон 7 албан хаагчдад 2.100.000 төгрөгийг тус тус олгосон байна.	100%
2.6	Албан хаагчдын нийгмийн асуудлыг	Тусламж, дэмжлэг олгосон албан	69	-	1-4 дүгээр улиралд	Төрийн захиргааны удирдлагын газар	1. Байгууллагын бага насны буюу цэцэрлэг, бага ангийн хүүхэдтэй 24 албан хаагчдын ар гэрийн амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, ажлын цагийн зохицуулалтыг оновчтой болгох	

	шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх.	хаагчдын тоо					зорилгоор өвлийн 2 сарын хугацаанд ажлын цаг эхлэх, дуусах хугацаанд уян хатан зохицуулалт хийсэн. /ТНБД 2024.01.04 А03 тушаал/ 2. Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйл болон Албан хаагчийн хүсэлтийг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй 1 албан хаагчийн хөдөлмөрийн нөхцөлийг хөнгөрүүлэх, 1 албан хаагчийн бага насны хүүхэдтэй байдлыг харгалзан, 1 албан хаагчийг эрүүл мэндийн шалтгаанаар, нийт 3 албан хаагчийг зайнаас болон цахим сүлжээгээр ажиллуулж цалин хөлсийг зохих журмын дагуу тооцож олгон нийгмийн асуудлыг тодорхой түвшинд шийдвэрлэсэн. 3. Эрүүл мэндийн шалтгаанаар 1 албан хаагч, ар гэрийн гишүүнээ асрах шалтгаанаар 5 албан хаагч, суралцах шалтгаанаар 3 албан хаагч, ар гэрийн гачигдал гарсан шалтгаанаар 3 албан хаагч, нийт 13 албан хаагчид чөлөө олгож, зохих олговрыг олгосон. 4. Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг тус яамны 70 албан хаагчид нийт 182,000,000 төгрөгийг олгосон. /ТНБД-ын 2024.12.26 А/193 дугаар тушаал/	100%
Гурав.Албан хаагчдын цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал урамшууллыг хууль тогтоомжид заасны дагуу олгох								
3.1	Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор баталсан цалингийн сүлжээг баримтлан албан хаагчдын цалин хөлсийг	Албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоосон, тушаалын тоо	1	1	1-4 дүгээр улиралд	Төрийн захиргааны удирдлагын газар Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс	1. МУЗГ-ын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан тушаалын цалин хөлсийг шинэчлэн тогтоож 2024.04.01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төрийн нарийн бичгийн даргын 2024.04.01-ний Б/45 дугаар тушаалаар цалин хөлсийг шинэчлэн тогтоож олгож байна. 2. МУЗГ-ын 2023 оны “Цалингийн хэмжээ итгэлцүүр, түүнийг хэрэглэх төрийн байгууллагын жагсаалт, орон тооны дээд хязгаар тогтоох тухай” 213 дугаар тогтоолоор мэдээллийн технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн өндөр ур чадвар бүхий 5 ажилтан ажиллуулах орон тоог баталсан. Уг тогтоолын дагуу	100%

	тухай бүр шинэчлэн тогтоож олгох.						тус яаманд гүйцэтгэх 2, туслах 2 ажилтан ажиллуулж цалин хөлсийг итгэлцүүрээр тогтоосон.	
3.2	Албан хаагчдад ажлын үр дүн, төлөвлөгөөни й гүйцэтгэл, мэргэшлийн түвшинг үнэлж, мөнгөн урамшууллыг хууль тогтоомжид заасны дагуу олгох.	Ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх үнэлгээний багийг байгуулсан шийдвэр, үр дүнгийн олгосон шийдвэр тоогоор	2	2	2,4 дүгээр улиралд	Зохион байгуулалт ын бүтцийн газар, нэгж	-Яамны албан хаагчдын 2024 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үндэслэн 66 албан хаагчид урамшууллыг 80 хувиар тооцож, Төрийн нарын бичгийн даргын 2024 оны А/154 дүгээр тушаалаар 120,869,500 төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон. Мөн Салбар зөвлөлийн дарга, гишүүдэд 2024 оны 1, 2 дугаар улирлын ажлын гүйцэтгэл үр дүнг үндэслэн Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 06 сарын 07- ны өдрийн Б/81 дүгээр тушаалаар удирдах 4 албан хаагчид албан тушаалын үндсэн цалингийн 20 хувиар, нарийн бичгийн даргад албан тушаалын цалингийн 30 хувиар тооцож нийт 5,077,600 төгрөгийн урамшууллыг тус тус олгосон. Мөн албан хаагчдын 2024 оны жилийн эцсийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үндэслэн нийт 60 албан хаагчид албан тушаалын үндсэн цалингийн 80 хүртэл хувиар нийт 104,089,000 төгрөгийн мөнгөн урамшууллыг олгосон бөгөөд үүнээс 54 нь маш сайн, 6 албан хаагч хэвийн үнэлэгдсэн. (ТНБД-ын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А179 дүгээр тушаал); -Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ыг үндэслэн яамны Ёс зүйн дэд хорооны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг харгалзан Ёс зүйн дэд хорооны гишүүд, нарийн бичгийн дарга нарт нийт 5,940,000 төгрөгийн мөнгөн урамшууллыг тус тус олгоод байна.	100%
3.3	Төрийн албанд ажилласан жил болон үр дүнг харгалзан	Төрийн албаны хаасан хугацааны нэмэгдэл болон	9	15	1-4 дүгээр улиралд	Төрийн захиргааны удирдлагы н газар	Тус яамнаас 2024 онд төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийг 22 албан хаагчид шинээр болон ахиулан олгосон, 4 албан хаагчид ажлын гүйцэтгэл үр дүнг үндэслэн хугацаанаас өмнө зэрэг дэвийг ахиулан олгосон.	

	зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгон, хууль тогтоомжид заасан бусад нэмэгдлийг олгох .	Төрийн захиргааны зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгосон албан хаагчдын тоо.					Ерөнхий сайдын захирамжаар 3 албан хаагчид “Эрхэлсэн түшмэл”-ийн зэрэг дэвийг олгосонтой холбоотой ТНБД-ын 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн Б/65 дугаар тушаалаар зэрэг дэвийн нэмэгдлийг албан тушаалын цалингийн 32 хувиар тооцож олгосон. Тус яамнаас 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 29 албан хаагчид зэрэг дэвийн нэмэгдэл болох 226,718,460.68 төгрөгийг зохих журмын дагуу олгосон байна.	100%
3.4	Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах.	Ахмад настуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний	27	27	1,4 дүгээр улиралд	Төрийн захиргааны удирдлагын газар Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс	Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг бөгөөд цагаан сарын баярыг тохиолдуулан 27 ахмад настанд 10.150.000 төгрөгийг мөнгөн тэтгэмж, ахмадын баярыг тохиолдуулан 27 ахмад настанд 19.600.000 төгрөгийг ахмадын баярын арга хэмжээ болон билэг дурсгалын зүйлд нийт 2 удаагийн арга хэмжээнд 54 ахмад настанд 29.750.000 төгрөгийг тус тус зарцуулсан.	100%
Дөрөв.Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, амралтын зохистой харьцаа бий болгох нөхцөл боломжоор хангах								
4.1	Албан хаагчдын ажлын байрны хэвийн	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг	-	Ажлын Байрны орчин нөхцөл хангагдс	1-4 дүгээр улиралд	-	Тус яамнаас 2024 онд албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийлээ. Үүнд: -Төрийн албаны тухай хууль болон байгууллагын дотоод журмыг үндэслэн бага насны 3 хүүхэдтэй 1	

	нөхцөлийг бүрдүүлэх.	хангасан байдал		ан байна.		албан хаагчийг зайнаас цахим сүлжээгээр ажиллуулж, цалин хөлсийг тооцон олгож байна. -Бүх нийтээр амрах баярын өдрүүдэд ажилласан 11 албан хаагч, амралтын өдрүүдэд болон илүү цагаар ажилласан албан хаагчдад 4 албан хаагчид илүү цагийн хөлсийг зохих журмын дагуу тооцож олгосон. -“Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-иар яамны байрны 42 өрөөний цонхыг шинээр сольж, 36 цонхны нугас, резин, түгжээг сольж засварлуулж, 1 давхрын 00 өрөөг бүрэн засвар хийлгэсэн. -Мөн яамны ажилчдын ажиллах нөхцөл, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор 6 нэр төрөл, 61 ширхэг нийт 179,842,628 төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж, 11 нэр төрөл, 97 ширхэг нийт 92,430,529.32 төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан бөгөөд 100,000,000 төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж худалдан авахаар тендер шалгаруулалт хийгдэж гэрээ байгуулах шатандаа явж байна. -Программ хангамжийн лиценз худалдан авах 40,000,000 төгрөгийн ажил, өвөлжилтийн бэлэн байдлыг хангах 80,000,000 төгрөгийн ажлууд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлагдан хуваарийн дагуу хийгдэж байна. - Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх үүднээс тус яам 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн ЦХХХЯ/20240102012 тоот гэрээний дагуу 4,750,000 төгрөгийн нэг бүрийн үнэтэй 10 ширхэг нөүтбүүкийг нийт 47,500,000 төгрөг , нэг бүрийн үнэ нь 2,350,000 төгрөгийн үнэтэй 10 ширхэг Дэлгэцийг/ 34”/ нийт 23,500,000 төгрөг, нэг бүр нь 525,000 төгрөгийн үнэтэй нэг үйлдэлт 2 ширхэг принтерийг нийт 1,050,000 төгрөг , нэг бүр нь 650,000 төгрөгийн үнэтэй олон үйлдэлт 3 ширхэг принтерийг 1,950,000 төгрөгөөр, нэг бүр нь 880,000 төгрөгийн үнэтэй 3 ширхэг скайнерийг 2,640,000 төгрөгөөр, Нэг бүр нь 4,200,000 төгрөгийн үнэтэй 1 ширхэг Ухаалаг дэлгэцийг / 65”/ 4,200,000	100%
--	-------------------------	--------------------	--	--------------	--	---	------

							төгрөгөөр, 5,500,000 төгрөгийн үнэтэй Мэргэжлийн аппарат 1 ширхэг 2,310,000 төгрөгийн үнэтэй Дуран 1 ширхэг нийт 98,000,000 төгрөгийн өртөг бүхий техник, тоног төхөөрөмжийг худалдан авч, ажилчдын ажиллах нөхцөлийг сайжруулсан.	
4.2	Албан хаагчдыг жилд 1-ээс доошгүй удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээ хийлгэх, эрүүл мэндийг хамгаалахад дэмжлэг тусалцаа үзүүлэх;	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан албан хаагчдын тоо	-	70	2 дугаар улиралд	Төрийн захиргааны удирдлагын газар Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс	1. Албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих, өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулахаар байгууллагын нийт 71 албан хаагчийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулсан. Уг ажлыг Хавдар судлалын үндэсний төв эмнэлэгтэй хамтран ажлын байранд эмч нарын баг ирж ажиллан, явуулын оношилгооны автобустай үзлэгийг ажлын байранд тус тус зохион байгуулж нийт 71 албан хаагчид 14.974.000 сая төгрөгийг зарцуулсан. 2. Албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих зорилгоор харьяа байгууллагаас зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээгээр “Эмч”-ийг түр ажлын байранд ажиллуулж албан хаагчдад эрүүл мэндийн шаардлагатай үйлчилгээг үзүүлж байна.	100%
Нийт үнэлгээний хувь								100%

-----oOo-----

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ СУРГАЛТ,
АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

2024 оны 02 дугаар сарын 27-ны өдөр

№ 10

Улаанбаатар хот

**НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО,
ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ**

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Засгийн газрын үйл ажиллагаан дах Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Яамны “Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2024 төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн түвшинг үнэлэхэд дээрх журмын “Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй” болон үр дүнг нотлох баримтад тулгуурлах зарчмыг баримтлан ажиллалаа.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Тус яамны албан хаагчдын “Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан 4 зорилтыг хэрэгжүүлэх 14 арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах үр дүн гарлаа. **Үүнд:**

1. Бүрэн хэрэгжсэн үр дүнтэй буюу 100%-ийн биелэлттэй – 14
2. Холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн гарч ирж байгаа, тодорхой үр дүнд хүрсэн буюу 90%-ийн гүйцэтгэлтэй -0
3. Дээд шатны байгууллагад өргөн барьсан, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70%-ийн гүйцэтгэлтэй - 0
4. Боловсруулалтын шатны арга хэмжээ хийгдсэн буюу 50 %-ийн гүйцэтгэлтэй - 0
5. Эрчимжүүлэх шаардлагатай шатанд байгаа буюу 30% гүйцэтгэлтэй- 0
6. Үр дүнгүй буюу 0%-ийн биелэлттэй– 0 заалт байна.

Үнэлгээ хийгдсэн 14 арга хэмжээний арифметик дунджаас үзвэл “Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2024 оны төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилт **100 хувь буюу “үр дүнтэй”** гэж үнэлэгдлээ. Энэхүү үнэлгээг 2024 оны жилийн эцсийн байдлаарх өссөн дүнгээр гаргасан болно.

“Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөнд туссан арга хэмжээнүүдээс 100 хувь буюу **“үр дүнтэй”** хэрэгжсэн онцлох ажлуудаас **дурдвал:**

1.Засгийн газар, төрийн бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт арга хэмжээний хүрээнд албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх зорилгоор засгийн газар

болон бусад байгууллагаас зохион байгуулсан 11 удаагийн сургалтад давхардсан тоогоор 455 албан хаагчийг хамруулсан. Үүнд:

- Удирдлагын академиас зохион байгуулсан Менторшип хөтөлбөрт 3 албан хаагч,
- Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад 19 албан хаагч,
- Critical thinking буюу эргэцүүлэх сэтгэлгээний арга барил, асуудалд бодитой хандах, нөхцөл байдлыг зөв үнэлж дүгнэн шийдвэр гаргах чадварыг сургалтыг нийт 45 албан хаагч,
- Албан хаагчдын нийгмийн баталгааны хөтөлбөр, хөдөлмөрийн дотоод журамтай холбоотой судалгаа, өөрчлөлтийн талаарх танилцуулах сургалт 20 албан хаагч,
- “Нийгмийн сүлжээн дэх эрх зүйн зохицуулалт”, “Хэвлэлийн өөрийн зохицуулалтын туршлага” /Герман Улс болон бусад орны сайн туршлагаас/ сургалтад 40 албан хаагч,
- JICE JDS Монгол дахь төлөөлөгчийн газраас “Хүний нөөцийг хөгжүүлэх JDS тэтгэлэгт хөтөлбөр”-ийн танилцуулах сургалтыг цахимаар нийт 25 албан хаагч оролцож мэдээлэл авсан,
- “Төрийн албан хаагчийн ёс зүй ба эрүүл мэнд” сургалтад 38 албан хаагч,
- Жендерийн Үндэсний хорооноос зохион байгуулсан “Жендерийн харьцаа” сэдэвт сургалтад 68 албан хаагч,
- Төрийн албаны зөвлөлөөс долоо хоног болгоны зохион байгуулдаг пүрэв гариг бүр зохион байгуулдаг “7:4:10” сэдэвт сургалтад нэг удаагийн 71 албан хаагч,
- Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулах, олон нийтийн авлигын талаарх мэдлэгийг дээшлүүлэх” цахим сургалтад 53 албан хаагч,
- Онцгой байдлын ерөнхий газраас зохион байгуулсан Гамшгийн үед ямар арга хэмжээ авах талаар сургалтад 73 албан хаагч тус тус оролцсон байна;

2. Цалин хөлс, шагнал урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газрын 2020-2024 оны хөтөлбөрт заасан зорилтыг биелүүлэх хүрээнд “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийг хэрэгжүүлэхэд орон нутагт дэмжлэг үзүүлэх ажилд 6 албан хаагч, МУ-ын Ерөнхий сайдын 2023 оны 206 дугаар захирамжаар байгуулагдсан эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд үр дүнтэй, идэвх санаачилгатай ажилласан 7 албан хаагчийг албан тушаалын сарын үндсэн цалингаар урамшуулсан, нийт 13 албан хаагчид Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн Б/71 дүгээр тушаалаар 26,760,000 төгрөгийн урамшуулал олгосон. Мөн эхний хагас жилийн гүйцэтгэлийн үнэлгээ, үр дүнг үнэлсэн урамшуулалд 65 албан хаагчдад Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн А/154 дүгээр тушаалаар 120,869,500.00 төгрөгийн урамшуулал, жилийн эцсийн гүйцэтгэлийн үнэлгээ, үр дүнгийн урамшуулалд 60 албан хаагчдад Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/179 дүгээр тушаалаар 104,089,000.00 төгрөгийн урамшууллыг тус тус олгосон.

3. Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд байгууллагын бага насны буюу цэцэрлэг, бага ангийн хүүхэдтэй 24 албан хаагчдын ар гэрийн амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, ажлын цагийн зохицуулалтыг оновчтой болгох зорилгоор өвлийн 2 сарын хугацаанд ажлын цаг эхлэх, дуусах хугацаанд уян хатан зохицуулалт хийсэн. /ТНБД 2024.01.04 А03 тушаал/

-Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйл болон Албан хаагчийн хүсэлтийг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй 1 албан хаагчийн хөдөлмөрийн нөхцөлийг хөнгөрүүлэх, 1 албан хаагчийн бага насны хүүхэдтэй байдлыг харгалзан, 1 албан хаагчийг эрүүл мэндийн шалтгаанаар, нийт 3 албан хаагчийг зайнаас болон цахим сүлжээгээр ажиллуулж цалин хөлсийг зохих журмын дагуу тооцож олгон нийгмийн асуудлыг тодорхой түвшинд шийдвэрлэсэн;

-Эрүүл мэндийн шалтгаанаар 1 албан хаагч, ар гэрийн гишүүнээ асрах шалтгаанаар 5 албан хаагч, суралцах шалтгаанаар 3 албан хаагч, ар гэрийн гачигдал гарсан шалтгаанаар 3 албан хаагч, нийт 13 албан хаагчид чөлөө олгож, зохих олговрыг олгосон;

-Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг тус яамны 70 албан хаагчид нийт 182,000,000 төгрөгийг олгосон. /ТНБД-ын 2024.12.26 А/193 дугаар тушаал/;

4. Албан хаагчдад ажлын үр дүн, төлөвлөгөөний гүйцэтгэл, мэргэшлийн түвшинг үнэлж, мөнгөн урамшууллыг хууль тогтоомжид заасны дагуу олгох ажлын хүрээнд яамны албан хаагчдын 2024 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үндэслэн 66 албан хаагчид урамшууллыг 80 хувиар тооцож, Төрийн нарын бичгийн даргын 2024 оны А/154 дүгээр тушаалаар 120,869,500 төгрөгийн мөнгөн урамшууллыг, 2024 оны жилийн эцсийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үндэслэн нийт 60 албан хаагчид албан тушаалын үндсэн цалингийн 80 хүртэл хувиар нийт 104,089,000 төгрөгийн мөнгөн урамшууллыг тус тус олгож үүнээс 54 нь маш сайн, 6 албан хаагч хэвийн үнэлэгдсэн. Мөн Салбар зөвлөлийн дарга, гишүүдэд 2024 оны 1, 2 дугаар улирлын ажлын гүйцэтгэл үр дүнг үндэслэн Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 06 сарын 07-ны өдрийн Б/81 дүгээр тушаалаар удирдах 4 албан хаагчид албан тушаалын үндсэн цалингийн 20 хувиар, нарийн бичгийн даргад албан тушаалын цалингийн 30 хувиар тооцож нийт 5,077,600 төгрөгийн урамшууллыг, "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ыг үндэслэн яамны Ёс зүйн дэд хорооны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг харгалзан Ёс зүйн дэд хорооны гишүүд, нарийн бичгийн дарга нарт нийт 5,940,000 төгрөгийн мөнгөн урамшууллыг тус тус олгосон.

5. Төрийн албанд ажилласан жил болон үр дүнг харгалзан зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгон, хууль тогтоомжид заасан бусад нэмэгдлийг олгох ажлын хүрээнд тус яамнаас 2024 онд төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийг 22 албан хаагчид шинээр болон ахиулан олгосон, 4 албан хаагчид ажлын гүйцэтгэл үр дүнг үндэслэн хугацаанаас өмнө зэрэг дэвийг ахиулан олгосон. Ерөнхий сайдын захирамжаар 3 албан хаагчид "Эрхэлсэн түшмэл"-ийн зэрэг дэвийг олгосонтой холбоотой ТНБД-ын 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн Б/65 дугаар тушаалаар зэрэг дэвийн нэмэгдлийг албан тушаалын цалингийн 32 хувиар тооцож олгосон. Тус яамнаас 2024 оны жилийн эцсийн байдлаар **нийт 29 албан хаагчид** зэрэг дэвийн нэмэгдэл болох **226,718,460.68 төгрөгийг** зохих журмын дагуу олгосон гэх зэрэг олон арга хэмжээг сайн гүйцэтгэж, амжилттай ажилласан байна.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны "Сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөний жилийн эцсийн

биелэлтийг хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгээс үзэхэд “үр дүнд хүрсэн” буюу хангалттай биелсэн гэж үзлээ.

Харин ажилчдын ажиллах нөхцөлийг сайжруулах арга хэмжээний хүрээнд албан хаагчдаас сэтгэл ханамжийн судалгааг авч нийт албан хаагчдын 85 хувь нь сэтгэл ханамжтай гэж хариулсан үзүүлэлт гарсан бөгөөд яамны барилга, шаардлага хангадаггүй өвөлдөө хүйтэн, дулаан алдагдал ихтэй, барилгын сан техник болон стандарт бус цонхны асуудлыг дурдсан нь үлдсэн 15 хувийг эзэлж байна. 2024 оны хувьд сургалт нийгмийн баталгааны хөтөлбөрт тусгагдсан хамгийн чухал арга хэмжээ болох албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд яамны удирдлагуудаас санаачилга гарган бүх албан хаагчдад нэг удаагийн мөнгөн тэтгэмж, олгосон нь сайшаалтай байлаа.

Иймд Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/129 дүгээр тушаалаар баталсан “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг 100 хувь буюу “үр дүнд хүрсэн” гэж дүгнэж байна.

Цаашид шинэчлэн батлуулах 2024-2026 онд хэрэгжүүлэх “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр”-т тусгах арга хэмжээнүүдийг албан хаагчдын ар гэр, нийгмийн байдлыг судлах дэлгэрэнгүй судалгааг хөндлөнгийн байгууллагаар хийлгэж, судалгаанд үндэслэн хэрэгцээ, шаардлагатай арга хэмжээг тусгах нь зүйтэй байна.

ДӨРӨВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ / ЗӨВЛӨМЖ /

Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд дараах зөвлөмжийг хүргүүлж байна. **Үүнд:**

Яамны Төрийн захиргаа, удирдлагын газарт:

1. Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөг оны эхэнд батлуулж хэвших;
2. Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт, төсвийн саналаа яамны ирэх оны төсвийн төсөөлөлд хуулийн хугацаанд тусгуулах;
3. Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд тэдний хэрэгцээ шаардлагыг тодорхойлох дэлгэрэнгүй судалгааг гаргаж, судалгаанд үндэслэн үр дүнтэй ажлуудыг зохион байгуулах;
4. Байгууллагын дотоод журмаар албан хаагчдад олгож байгаа мөнгөн тэтгэмжийг тухайн үед мөрдөгдөж буй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх ажлыг холбогдох газар, хэлтэс зохион байгуулж байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусган, хэрэгжилтийг хангаж ажиллах;
5. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тайлантай танилцаж холбогдох баримт материалыг судлан үзэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулах зэрэг боломжит хугацааг анхаарч тайлагнах;

Жич: Дээрх зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжилтийг хангаж, ажиллах үүрэгтэй бөгөөд тайланг хугацаандаа нэгтгэн, баталгаажуулж, тайлагнаагүй бол холбогдох албан тушаалтанд зохих хууль, журмын дагуу хариуцлага тооцохыг үүгээр мэдэгдэж байна.

Мөн 2024-2026 онд хэрэгжих сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулахдаа Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас

өмнөх жилүүдэд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө авч хамтран ажиллахыг хүсье.

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА



Ц.БОРХҮҮ

ТАЙЛАН БИЧСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН



М.МӨНХТУУЛ